


Ерөнхийлөгч  
Томас С.Монсон



# “Би та нарыг хайрласны адилаар”

Льюс гэдэг найз маань хэдэн жилийн өмнө уян зөөлөн эхийнхээ тухай дурсамжаа хуваалцсан юм. Эх нь нас барахдаа өөрийн хүү, охидод хөрөнгө мөнгө үлдээгээгүй ч үлгэр жишээ, золиослол, дуулгавартай байдлын өв үлдээжээ.

Оршуулгын газар руу гашуудлын цуваа хөвөрч, оршуулах ёслол дээр түүнийг магтсан үгсийг хэлж байв. Үүний дараа гэр бүлийнхэн нь ээжийнхээ эдэлж хэрэглэж байсан зүйлийг цэгцэлж эхэлжээ. Эд зүйлийнх нь дотроос Льюс нэгэн бичгийг түлхүүрийн хамт олжээ. Уг бичигт “Унтлагын өрөөний буланд байдаг миний шүүгээний доод талын шургуулганд жижигхэн хайрцаг байгаа. Энэ хайрцганд миний сэтгэл шингэсэн эрдэнэс бий. Энэ түлхүүрээр хайрцгийг нээж болно” гэсэн заавар байв.

Бүгд л ээжид минь цоожлон байж үлдээх ямар зүйл байсан юм бол гэж гайхаж байлаа.

Хайрцгийг байсан газраас нь гаргаад, түлхүүрээр болгоомжтой гэгч онгойлгов. Льюс бусадтайгаа хамт хайрцган доторхыг хартал хүүхэд бүрийн ганцаараа авахуулсан зураг мөн зураг болгон дээр нэр, төрсөн өдрийг бичсэн байхыг харав. Үүнээс гадна Льюс гараар бичсэн нэгэн хайрын захидал олжээ. Тэрээр үүнийг хүүхэд байхдаа сарайлган бичсэн өөрийн захидал болохыг таниад, 60 жилийн өмнө бичсэн “Хайрт ээж минь, тандаа хайртай” гэсэн үгсийг уншив.

Зүрх сэтгэл нь уярч, хоолой нь зангиран, нүд нь нулимсаар дүүрэв. Ээжийнх нь үнэт эрдэнэс мөнхийн гэр бүл нь байжээ. Үүний хүч чадал “Би танд хайртай” гэсэн үгийн бат бөх суурин дээр оршиж байв.

Өнөөгийн дэлхийд гэр орноос өөр хаана ч хайрын бат бөх суурь байхгүй. Мөн хайрыг гэр бүлийнхээ гол

утга учир болгосон хожмын үеийн гэгээнтнүүдийн гэр орноос илүү сайн, ийм суурь болох жишээ дэлхийн хаанаас ч олдохгүй.

Аврагч Есүс Христийн шавь болох бид бүхэнд Тэрээр энэхүү алс хэтийг харсан зааврыг өгчээ.

“Би та нарт бие биенээ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна.

Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно”<sup>1</sup>

Хэрэв бид бие биенээ хайрлах зарлигийг дагах юм бол өдөр бүр харилцахдаа бие биендээ хайртай гэдгээ харуулж, нэг нэгэндээ эелдэг даруу, хүндэтгэлтэй хандах болно. Хайр нь сайхан үг, тэвчээртэй хариулт, амиа бодоогүй үйлдэл, ойлгож сонсдог сонор, уучилдаг зүрх сэтгэлийг өгдөг. Бидний бүхий л харилцаанд илэрдэг эдгээр болон иймэрхүү үйлдлүүд бидний зүрх сэтгэл дэх хайрыг олж харахад бусдад туслах болно.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) “Хайр . . . солонгын төгсгөл дэх алттай ваар юм. Энэ нь солонгын төгсгөлөөс илүү дээр. Хайр мөн эхлэл билээ. Үүнээс шуургатай өдөр ч тэнгэрт нумлан татсан гоо үзэсгэлэн урган гардаг. Хайр бол хүүхдүүдийн уйлдаг, өсвөр үеийнхний хүсэн эрмэлздэг, гэрлэлтийг холбодог, гэр орон дахь сүйрүүлэх сөргөлдөөнийг холдуудаг хамгаалалт юм. Энэ нь хөгшдийн амар амгалан байдал мөн үхэл хагацалтай тулгарсан үед гэрэлтэх найдварын гэрэл юм. Гэр бүл, найз нөхөд, Сүм, хөршүүдтэйгээ харьцахдаа хайрыг мэдэрдэг хүмүүс хэчнээн баян билээ”<sup>2</sup> хэмээн бичжээ.

Хайр бол сайн мэдээний хамгийн чухал хэсэг бөгөөд хүмүүний бодгалийн хамгийн сайхан зан чанар билээ. Хайр өвдөж шаналсан гэр бүл, сөрөг үзэгдлээр дүүрэн нийгэм болон, эрүүл бус үндэстэнд эм эмчилгээ болдог. Хайр бол инээмсэглэл, гараараа далах мэндчилгээ, эелдэг үг, магтаалд оршино. Хайр бол золиослол, үйлчлэл, амин хувиа үл хичээх явдал юм.

Нөхрүүд ээ, эхнэрүүдээ хайрла. Тэднээр бахарх. Тэдэнд талархалтай ханд. Эгч нар аа, нөхрүүдээ хайрла. Тэднийг хүндэл. Тэднийг урамшуулан дэмж.

Эцэг эхчүүд ээ, хүүхдүүдээ хайрла. Тэдний төлөө залбирч, тэдэнд заа мөн гэрчил. Хүүхдүүд ээ, эцэг эхээ хайрла. Тэдэнд хүндэтгэлтэй ханд. Талархлаа илэрхийл. Дуулгавартай бай.

Христийн цэвэр хайргүйгээр “[бид] юу ч биш” хэмээн Мормон зөвлөсөн.<sup>3</sup> Мормоны “[бид] түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр цутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө; [бид] Бурханы хөвгүүд болж болохын тулд; тэрбээр хүрч ирэхэд [бид] түүнтэй адил байх болно, . . . зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирагтун” (Моронай 7:48) хэмээх зөвлөгөөг бид дагаасай хэмээн би залбирч байна.

#### ЭШЛЭЛҮҮД

1. Иохан 13:34–35.
2. Гордон Б.Хинкли, “And the Greatest of These Is Love,” *Ensign*, 1984 оны 3-р сар, 3.
3. Моронай 7:46; мөн 44-р шүлгийг үзнэ үү.
4. Моронай 7:48.

## ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Монсон жинхэнэ Христийнхтэй адил хайраар гэр бүлийнхнээ онцгойлон хайрлахын ач холбогдлын тухай заав. Айлчлан очдог хүмүүсээ гэр бүлээрээ цуглаад, нэг нэгэндээ хайраа харуулах арга замуудын тухай ярилцахад урих талаар эргэцүүлэн бод. Та эдгээр арга замаас аль нэгийг сонгоод, гэр бүлээрээ хамтдаа хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргахад урамшуулан дэмжиж болно. Жишээлбэл: гэр бүлийн гишүүд гэр бүлийнхээ хэн нэгэнд долоо хоног бүр нууцаар үйлчлэл хийх арга зам хайж болно. Та тэднээс гэр бүлийнхнээ улам их хайрлах зорилгодоо хүрэхийн тулд хэрхэн хичээж зүтгэх талаар тунгаан бодохыг дараа нь хүсэж болно.

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

### Амар амгалангийн төлөө залбирсан нь

Сара Т.

**М**анай эцэг эх Сүмийн цуглааны дараа хурал, уулзалтад явдаг байсан бөгөөд би гурван эрэгтэй

дүүгээ харж үлдээд, өдрийн хоол хийхэд тусалдаг байв. Гэсэн ч тэд заримдаа өлсөөд, тэвчээргүй загнадаг байлаа. Ихэнх тохиолдолд тэднийг муудалцаад зодолдож эхэлбэл би тэрүүхэндээ асуудлыг нь шийдчихдэг байв. Гэхдээ зарим үед тэднийг зодолдоод эхлэхэд л би цухалдаад эхэлдэг учраас тэднийг эвлэрүүлэхэд хэцүү байдаг байсан.

Нэг өдөр дүү нар маань хоорондоо таарахгүй тун хэцүү байлаа. Би өөрөө сэтгэл тавгүй байсан болохоор тэднийг эвлэрүүлэх гэсэн оролдлого маань байдлыг улам дордуулж байна гэдгийг мэдэв. Тэгээд л би өөрийнхөө хоолыг хийчихээд, тэдэнтэй дуугарсангүй. Эцэст нь “Би залбирах гэж байна. Та нар жаахан ч гэсэн чимээгүй байж болох уу?” гэж асуув. Тэднийг аядуу болмогч би хоолоо адислахыг гуйн залбираад, залбирлаа дуусгахаасаа өмнө “Биднийг энх амгаланг тогтоогч болоход тусална уу” хэмээн нэмж хэлэв.

Эхлээд тэд сонсохгүй, дахиад л зодолдож гарав. Надад түвэгтэй санагдаж байсан боловч амар амгаланг гуйж залбирсан учраас тэднийг хайрлан, амгалан тайван байх хэрэгтэй гэдгээ би ойлгож билээ. Нэг минут өнгөрөхөд тайвширсан мэдрэмж төрөв. Би үг дуугүй хоолоо идэж эхлэв. Хөвгүүд ч зодолдохоо болилоо. Миний мэдэрсэн амар амгалан жирийн нэг залбирлын хариу байсан гэдгийг би ухаарсан юм. Би энх амгаланг тогтоогч болохыг гуйн залбирсан бөгөөд Тэнгэрлэг Эцэг минь намайг орилж хашхирмаар санагдсан үедээ амар тайван байхад тусалсан билээ. Тэрээр бидэнд үнэхээр амар амгаланг өгдөг гэдгийг би мэднэ.

*Зохиогч нь АНУ-ын Аризонад амьдардаг.*

## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### Жинхэнэ үнэт эрдэнэс

**Е**рөнхийлөгч Монсон үнэт эрдэнэсийнх мэт нэгэн нандин хайрцагтай байсан эхийн тухай түүхийг өгүүлэв. Тэр эмэгтэйн хүүхдүүд хайрцгийг нээгээд, өөрсдийнхөө зургийг дотор нь байхыг харсан юм. Эхийн үнэт эрдэнэс мөнхийн гэр бүл нь байжээ.

Жинхэнэ үнэт эрдэнэс бол алт мөнгө, үнэтэй эд зүйлс биш юм. Энэ бол таны хайрладаг хүмүүс юм. Та хэнийг хайрладаг вэ? Үнэт эрдэнэсийн хайрцаг зураад, хайртай хүмүүсийнхээ зургийг эсвэл нэрийг хий.

© 2017 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/16. Орчуулгын зөвшөөрөл: 6/16. *First Presidency Message, February 2017*-гийн орчуулга. Mongolian. 97922 363



# Есүс Христийн Цагаатгал Бурханы хайрын илрэл юм

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийн тулд сунслээ өдөөлтийг эрэлхийл.

Итгэл, гэр бүл, халамж

Тэнгэрлэг Эцэг маань Төрсөн Ганц Хүүгээ биднийг үхэшгүй мөнх амьдрал болоод мөнхийн амьдралд тохирох чадавхтай болгохын тулд өгсөн гэдгийг ойлгох нь биднийг гэсэн Бурханы хязгааргүй бөгөөд бидний ойлголтоос давсан хайрыг мэдрэхэд тусалдаг. Аврагч маань бидэнд хайртай.

“Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? . . .

Учир нь үхэл ч, амь ч, тэнгэр элч нар ч, эрх баригчид ч, өнөөгийн юмс ч, ирэх юмс ч . . .

Өндөр ч, гүн ч, өөр ямар ч бүтээл бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй гэж би бат итгэлтэй байна” (Ром 8:35, 38–39).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон “Аврагч Гетсеманид болон загалмай дээр зовон шаналснаараа

бидэн дээр ирэх шударга ёсны шаардлагуудыг хангаж, биднийг нүглээс гэтэлгэсэн юм. Тэрээр наманчилдаг хүмүүсийг уучилж, ариусгадаг. Цагаатгал нь бас бусдын буруу үйлдлээс учирсан зовлон зүдгүүрээс биднийг анагааж, хохирлыг нөхөн барагдуулах шударга ёсны шаардлагыг хангадаг. ‘Учир нь болгоогтун, тэрээр бүх хүмүүний шаналлыг тэвчинэ, тийм ээ, амьдрагч бүхний шаналлыг, Адамын гэр бүлд багтах эр, эм, мөн хүүхэд аль алиныхыг нь болой’ (2 Нифай 9:21; мөн Алма 7:11–12-ыг үзнэ үү).”<sup>1</sup>

Христ “алгандаа [биднийг] сийлсэн” гэж хэлсэн (Исаиа 49:16). Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бертон “бидний гэм нүгэл, зүрхний шаналал, хувийн амьдралд маань шударга бус санагдах бүхний төлөө зовохоор Өөрийн Төрсөн Ганц, төгс төгөлдөр Хүүг илгээсэн

хайрын тэр агуу үйлдлийнх нь төлөө Тэнгэрлэг Эцэгтээ хандан өвдөг сөхрөн даруухнаар талархан залбирах ёстой”<sup>2</sup> гэж хэлсэн.

## Нэмэлт судар, мэдээлэл

Иохан 3:16; 2 Нифай 2:6–7, 9; [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org)

## ЭШЛЭЛҮҮД

1. Д. Тодд Кристоффэрсон, “Гэтэлгэл” 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 129,
2. Линда К.Бертон, “Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэл бидний зүрхэнд бичигдсэн үү?” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 139.

## Үүнийг эргэцүүлэн бод

Бид Бурханд болон Есүс Христэд Аврагчийн Цагаатгалын бэлгийн төлөө хэрхэн хайр, талархлаа илэрхийлж болох вэ?